



Hunan Industrial Equipment Installation Co., Ltd.
Add: No 446, Guyuan Road, Changsha, Hunan, China

Tel: +86-731-85926682

E-mail: hnzlw@163.com

Утас: +976 89696989

2024.09.26 № S-009-025

Тайлбар: _____ -ийн № _____ -ий

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-Т

Тодруулга авах тухай

Манай компани нь Үйлдвэрлэл технологийн паркийн гадна цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээг барьж байгуулах ажлын БАГЦ-№1 " 220/110/35 кВ-ын 2х200 МВА чадалтай "Оюут" дэд станцыг барих ажил."-ын тендерт оролцож байна.

Тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу 200МВА хүчин чадалтай үндсэн трансформаторын ачаалалгүй алдагдал 37кВт, ачааллын алдагдал 200кВт, гурван фазын эсэргүүцэл 11,35,22 тус тус байна. Бид дотоодын болон олон улсын нэр хүндтэй брэнд үйлдвэрлэгчидтэй холбогдож зөвлөлдсөн боловч тэдгээрийн аль нь ч тус параметрийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа бөгөөд одоогийн байдлаар бидний тодруулснаар ачаалалгүй алдагдал 58кВт, ачааллын алдагдал 425кВт байна. Иймд тус тендерт ирүүлсэн параметрууд зөв оновтой эсэхийг баталгаажуулна уу.

Тендерт тусгагдсан ихэнхи цахилгаан тоноглолуудын үйлдвэрлэлийн стандарт нь IEC боловч дотоодын үйлдвэрлэгчдийн хангаж чадах стандарт нь зөвхөн Хятадын үндэсний стандарт тул Захиалагчийн зүгээс эдгээрт стандартад өөрчлөлт оруулах боломжтой эсэх талаар тодруулж өгнө үү.

ХУНАН ИНДАСТРИАЛ ЭКВИПМЕНТ ИНСТАЛЭЙШН ХХК-ИЙН

МОНГОЛ ДАХ ТӨЛӨӨЛӨГЧ *2/09/25* ВАН ЖЕНЖУНГ



Add: No 446, Guyuan Road, Changsha, Hunan, China

Tel: +86-731-85926682

Утас: +976 89696989

E-mail: hnzlw@163.com



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИГ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.10.01 № 29/133

танай _____-ны № _____-т

Тодруулгад харну өгөх тухай

Үйлдвэрийн газрын Үйлдвэрлэл, технологийн паркийн гадна цахилгаан хангамжийн зураг төслийн ажлын “220/110/35 кВ-ын 2х200 МВА чадалтай ОЮУТ дэд станцыг барих ажил”-ын тодруулгад дараах харнут хүргүүлж байна. Үүнд:

Монгол улсын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд стандартчиллын баримт бичигт:

1. Монгол улсын /үндэсний/ стандарт,
2. Олон улсын болон бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, түүнд нийцүүлэн гаргасан гадаад улсын стандартыг авч үзнэ гэж заасан байдаг.

Иймээс манай хүрээлэн зураг төсөлдөө Олон улсын цахилгаан техникийн хорооны стандарт болох IEC стандартыг тусгаж өгсөн.

Автотрансформаторын ачаалалгүй болон ачаалалтай үеийн алдагдал болон бусад техникийн үзүүлэлтүүд нь IEC 60076 багц стандартын шаардлагыг хангасан байхад болно.



Зураг төслийн хүрээлэн
Захирал
Давдай Тамир
2024.10.01 16:40